







# ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

# ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

---

2017.06.23

# АГУУЛГА

 <p>ШИНЭ</p>	<ul style="list-style-type: none"><li>▪ Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол</li></ul>
 <p>ҮРГЭЛЖИЛЖ БАЙГАА</p>	<ul style="list-style-type: none"><li>▪ Хачигт халдварын 7 хоногийн мэдээ</li><li>▪ Галзуу өвчний 7 хоногийн мэдээ</li><li>▪ Мал, амьтны өвчлөл</li><li>▪ ДАЭМБ-ын мэдээ</li></ul>
 <p>АРГА ХЭМЖЭЭ</p>	<ul style="list-style-type: none"><li>▪ Эрсдэлийн үеийн харилцаа холбоо</li></ul>
 <p>ХААСАН</p>	<ul style="list-style-type: none"><li>▪ Байхгүй</li></ul>

Дотоод албан хэрэгцээнд




# ШИНЭЧЛЭГДСЭН МЭДЭЭ: ГАЛЗУУ, ХАЧИГТ ХАЛДВАР 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

---




# ХАЧИГТ ХАЛДВАРЫН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ N=1038



Он гарсаар хачгаар дамжих халдварт өвчний нийт 1038 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үе (508)-ээс 2.1 дахин өндөр үзүүлэлттэй байна. Тандалтын 25-р долоо хоногт 31 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна.

# ГАЛЗУУ ӨВЧНИЙ ЭРСДЭЛД ӨРТСӨН ТОХИОЛДОЛ, (N=100)



- 2017 онд тархвар судлалын тандалтын эхний 25 долоо хоногийн байдлаар галзуугийн эрсдэлд өртсөн 100 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.2 дахин их бүртгэгдсэн байна.

# ХУМХАА ӨВЧНИЙ СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ

Нас, хүйс	32 настай, эрэгтэй
Иргэншил	Бүгд Найрамдах Конго Улс
Түр оршин суугаа хаяг	Монгол улс, Эрдэнэт хот (3жил)
Хөдөлмөр эрхлэлт	- ТББ
Тархвар судлалын холбогдол (Аялалын өгүүлэмж)	- БНКУ-д 2016 оны 12 сараас 2017 оны 2 сар хүртэл байсан.
Шинж тэмдэг илэрсэн огноо	2017.06.19
Эмнэлэгт үзүүлсэн/Эмнэлэгт хэвтсэн	2017.06.19 Интермэд эмнэлэгт хэвтсэн
Эмнэлзүйн шинж тэмгүүд	Гэнэт 39-40° хэм халуурах, толгой хүчтэй өвдөх, бүх бие янгинах, ухаан балартах
Урьдчилсан онош	A52
Шинжилгээний дүн	2017.06.21-ний өдрийн Молекул биологийн шинжилгээгээр хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй тул оношийг үгүйсгэсэн

Дотоод албан хэрэгцээнд

**МАЛ, АМЬТНЫ ӨВЧЛӨЛ**

---

# МАЛ, АМЬТНЫ ӨВЧЛӨЛ: БООМЫН МАЛЫН ӨВЧЛӨЛИЙН МЭДЭЭ

<b>Эх сурвалж</b>	<b>ОБЕГ</b>
<b>Хугацаа</b>	<b>2017.06.10</b>
<b>Хаана</b>	Архангай аймгийн Өндөр-Улаан сум, Баянгол багийн “Цуурайн-Ам” гэдэг газар
	<ul style="list-style-type: none"><li>• Малчин өрх “Б”-ийн 24 үхэр мал, амьтны гоц халдварт боом өвчний шинж тэмдэг илэрч, өвчилсөн малаас дээж авч, аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд боомоор өвчилсөн болох нь тогтоогдсон. 2017 оны 6 дугаар сарын 21-ний байдлаар малчин өрх “Б”-ийн 71 үхэр мөн 4 өрх айлын нийлсэн 24 үхэр нийт 96 үхэр боомоор өвчилж үхсэн.</li><li>• Өндөр- Улаан сумын засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/59 дугаар захирамжаар 2017.06.11-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосон.</li><li>• Архангай аймгийн засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн А/248 тоот тушаалаар ОБГ, МХГ, ЗӨСТ, ХААТ байгууллагын 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажилласан.</li><li>• 5 өрхийн 96 үхэр, 13 хонь (дотрын халдварт хордлого), 5 нохой (эзний хүсэлтээр) нийт 114 малыг устгаж, халдваргүйтгэл хийсэн.</li><li>• 4 хот айлийн 2938 үхэр, 890 хонь, нийт 3828 малыг боомын эсрэг вакцинжуулалтанд хамруулсан.</li><li>• Хөл хорионы бүсэд байгаа 28 өрхийн 94 хүнд 8 удаагийн сургалт, сурталчилгаа хийж, 142 санамж тараасан. Голомтын бүсэд үхсэн малтай харьцах, асарч сувилах, устгах үедээ гартаа ил шархтай байсан 11 хүнд үзлэг хийж, шархыг цэвэрлэн боолт хийж, биеийн халууныг өдөрт 2 удаа үзэн тэмдэглэж байна.</li><li>• 58 хүнийг үзлэгт хамруулснаас ципрофлоксацинаар 27 хүн, ципрофлоксацин+пенициллин G хавсарсан эмчилгээнд 15 хүн, нийт 49 хүнийг урьдчилан сэргийлэх эмчилгээнд оруулж, хяналт тавьж, биеийн эсэргүүцэл сайжруулах зорилгоор витамин С уулгаж байна</li></ul>
<b>Авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ</b>	



# МАЛ, АМЬТНЫ ӨВЧЛӨЛ: Мал амьтны галзуу өвчин

Хугацаа	Хаана	Үйл явдлын мэдээлэл	Хариу арга хэмжээ
2017.06.18	Архангай аймгийн Жаргалант сумын Зуслан багийн “Таравтын-Ам” гэдэг газар	малчин “Б”-ийн хотонд 2017.06.18-ны өдөр галзуу өвчний сэжигтэй үнэг дайрсан ба уг үнэгийг устгаж, дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд “Галзуу” өвчин болох нь 2017.06.19-ны өдөр батлагдсан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Жаргалант сумын Засаг даргын 2017.06.19-ний өдрийн А/72 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон.</li> <li>- 06.20-ны өдрийн байдлаар 129 малыг вакцинжуулж, 1 үнэгийг устгасан</li> <li>- 150 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн.</li> </ul>
2017.06.18	Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Чандманьхайрхан багийн “Үенч-Өндөр” гэдэг газар	малчин “М”-ийн 1 сарлагийн үнээ галзуу өвчний шинж тэмдэгтэй өвчилсөн тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 2017.06.20-ны өдрийн 17-220 дугаар хариугаар “Галзуу” өвчин болох нь тогтоогдсон байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Баян-Уул сумын Засаг даргын 2017.06.19-ний өдрийн А/61 дүгээр захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон.</li> <li>- Голомтын бүсэд 1 үхрийг устгаж, 398 үхрийг вакцинжуулсан</li> <li>- 600 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн.</li> </ul>
2017.06.20	Булган аймгийн Баян-Агт сумын Шаргын багийн “Шар-Агт” гэдэг газар	малчин “С”-ийн 1 үхэр 2017.06.20-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй өвчилсөн тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 2017.06.20-ны өдрийн 279/280 дугаар хариугаар “Галзуу” өвчин болох нь тогтоогдсон байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Баян-Агт сумын Засаг даргын 2017.06.21-ний өдрийн А/72 дугаар захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон.</li> <li>- Голомтын бүсэд 1 үхрийг устгасан.</li> <li>- 500 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийсэн.</li> <li>- Голомтод 7 өрхийн 4393 мал байна.</li> </ul>

## МАЛ, АМЬТНЫ ӨВЧЛӨЛ: ШҮЛХИЙ ӨВЧИН

Эх сурвалж	ОБЕГ
<b>Хугацаа</b>	<b>2017.06.19</b>
<b>Хаана</b>	Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, “Тахилт”-ын 6 дугаар гудамжны 327 тоотод
<b>Үйл явдлын мэдээлэл</b>	иргэн “Ж” –ийн 4 үхэрт мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний шинж тэмдэг илэрч, өвчилсөн малаас дээж авч, нийслэлийн МЭАЦТЛ-д шинжлүүлэхэд 2017.06.19-ний өдрийн 17-4309 тоот хариугаар “Шүлхий” өвчин болох нь тогтоогдсон.
<b>Авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ</b>	<ul style="list-style-type: none"><li>- Тус дүүргийн Засаг даргын 2017.06.20-ны өдрийн А/310 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон.</li><li>- 2017.06.21-ны өдрийн байдлаар 27 үхэр, 1 нохойг зориудаар устгасан</li><li>- Цагдаа, ОБЕГ, МХЕГ Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүд хөл хорио тогтоох, халдваргүйтгэл, устгалын арга хэмжээ авч ажиллаж байна.</li></ul>

# ДАЭМБ-ЫН МЭДЭЭ

---


# Өндөр хоруу чанартай шувууны томуугийн А(Н5N8) вирус халдварын шувууны өвчлөл

Эх сурвалж	<a href="http://www.promedmail.org/">http://www.promedmail.org/</a>
Хугацаа	2017.06.16
Хаана	<b>Бельгийн Вант Улс</b>
Өртсөн тоо	<ul style="list-style-type: none"> <li>- сэжигтэй шувуу 4047</li> <li>- өвчилсөн 1650,</li> <li>- 500 үхэж,</li> <li>- 3547 шувууг устгасан байна.</li> </ul>
Хариу арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>-Өвчлөл гарсан бүс нутагт тандалт хийх /хамгаалах</li> <li>- Халдваргүйтгэлийн арга хэмжээ авах</li> <li>- Эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн ажиллах</li> </ul>



# Холер өвчний дэгдэлт: Йемен улс

Эх сурвалж	<a href="http://www.promedmail.org/">http://www.promedmail.org/</a>
Хугацаа	2017.04.27-2017.06.20
Хаана	Йемен улс
Өртсөн тоо	Сэжигтэй тохиолдол 166976, нас баралт 1146-д хүрсэн байна.
Хариу арга хэмжээ	<ul style="list-style-type: none"><li>- Халдваргүйтгэлийн арга хэмжээ авах</li><li>- Эрсдэлийн үеийн харилцаа холбоог эрчимжүүлэн ажиллах</li></ul>



# ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ: ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБОО

---

# Эрсдэлийн үеийн харилцаа холбоо

- Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Баянгол багийн “Цуурайн-Ам” гэдэг газар гарсан боомын малын өвчлөлөөр 5 өрхийн нийт 96 үхэр үхсэн тул Архангай аймгийн ЗӨСТ, ЗӨСҮТ хамтран эрсдэлийн үнэлгээ хийж, ЭМЯ, ХӨСҮТ, аймаг нийслэлийн ЗӨСТөвүүд болон ЭМГ-уудад, ОБЕГ-д эрсдэлийн үнэлгээний дүн, зөвлөмжийг хүргүүлж ажиллав.

# ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО



- NTV
- Малчин
- Royal HD
- МН 25





# ЭРСДЭЛИЙН ҮЕИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО



Хачигт энцефалит өвчний

## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

Ямар үед хачигт хазуулах эрсдэлтэй вэ?



Ой модонд:

- \* ажил эрхлэх
- \* зугаалах
- \* жимс, эмийн ургамал түүх
- \* ууланд алхах

Ой мод, хээр явахдаа хачигт хазуулахаас урьдчилан сэргийлэх энгийн 7 арга:

- 1 Явган явахдаа жим голлож, өндөр өвс бутнаас зайдуу явах
- 2 Урт ханцуйтай цамц өмсөх
- 3 Хачиг харагдахаар цагаан эсвэл тод өнгийн хувцас өмсөх
- 4 Малгай өмсөх
- 5 Ой модонд ажиллаж, аялахаас өмнө гутал хувцасруугаа хачиг дайжуулагч цацах
- 6 Өмдөө гутлын түрийний дотуур хийж өмсөх
- 7 Урт түрийтэй гутал өмсөх



nczd.gov.mn

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

70282853

## ХАЧИГТ ЭНЦЕФАЛИТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЬЕ

Монгол улсад хачигт энцефалит өвчнийг дамжуулагч үндсэн хачиг нь ойн мод бүхий нутагт өргөн тархсан хачиг юм.

Хачигт энцефалит өвчний байгалийн голомт:



Хачигт энцефалит өвчний онцлог шинж:



Хэрэв та хачигт хазуулснаас хойш 7-14 хоногийн дараа дээрх шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт яаралтай хандаарай !!!



Хачигт халдвараас сэргийлэх энгийн 7 арга инфографик

# МЭДЭЭНИЙ ХАНДАЛТ




## Фэйсбүүк хуудсанд

- 13332 хүн хандсан.
- 16 хуваалцсан



## Байгууллагын цахим хуудсанд

- 616 хүн хандсан



**НИЙТ: ХҮН ХАНДСАН**



ЗМҮГС  
СЛОРТЫН ХАН



**ШУУРХАЙ  
УДИРДЛАГЫН  
НЭГЖ**

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**